



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

159 /159/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.10.19

## ҮЙЛ ЯВДАЛ

### “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АР ТАЛ-100” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ



Зэвсэгт хүчний ар талын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Зэвсэгт хүчний ар тал-100” эрдэм шинжилгээний онол практикийн бага хурал өчигдөр зохион байгуулагдлаа. Тус хуралд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба, Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, МТГ-ын үе үеийн дарга нар, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудын төлөөлөгчид болон Зэвсэгт хүчний Материал, техникийн газрын харьяа ангийн захирагчид оролцсон юм.

Тус хурлыг ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр нээсний дараа “Орчин цагийн Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын албаны нэгэн зуун жилийн хөгжил, дэвшил ба шинэ зуунд дэвшигдэж буй зорилт” үндсэн илтгэлийг Материал, техникийн газрын орлогч, техникийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Төрмөнх тавьсан юм. Үргэлжлүүлээд МТГ-ын Техникийн хэлтсийн Ерөнхий инженер-техникийн хангалт, нөөцийн

төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Энхболд “Зэвсэгт хүчний техникийн хангалтын хөгжил, цаашдын чиг хандлага”, МТГ-ын Зэвсгийн хэлтсийн дарга, хурандаа П.Чинзориг “Зэвсэгт хүчний зэвсэг, галт хэрэглэлийн хангалт, хөгжлийн чиг хандлага” зэрэг хавсралт илтгэлүүдээс гадна Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч, хурандаа М.Батдорж “Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд засварын хорооны үүрэг”, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч, хурандаа Д.Нямгэрэл “Галт хэрэглэл ба Зэвсэгт хүчний 015 дугаар анги” зэрэг илтгэлүүдээр үргэлжилсэн юм.

Материал, техникийн газар болон харьяа ангийн бие бүрэлдэхүүн, хамт олон сүүлийн жилүүдэд түүхт ойгоо угтаж том том зорилго, зорилтуудыг дэвшүүлж, Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын тогтолцоог боловсронгуй болгох, Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, материал, техникийн бүх төрлийн хангалт, үйлчилгээг

тасралтгүй явуулах, ажиллаж амьдрах аятай орчныг бүрдүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн зарим асуудлыг шийдэхэд ажлаа чиглүүлж, багагүй арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, түүхт ойгоо ажлын бахдам амжилт, бүтээл арвинтайгаар тэмдэглэж байгаа юм.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан стратегийн баримт бичгүүд, ялангуяа Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги- 2030” гэдэг стратегийн баримт бичгийг батлан гаргаж, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, эдүгээ Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020-2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа юм. Мөн хөтөлбөрийн зорилгод өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангагдсан чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох эрхэм зорилгод нийцүүлэн Зэвсэгт хүчний



хөгжлийг эрчимжүүлж, улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх гэж тусгасан.

Дээрх зорилгод хүрэхийн тулд гаргасан зорилтуудад “Цэргийн нэгтгэл, ангийн зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах”, “Цэргийн материал хэрэгслийн хангалтын тогтолцоог шинэчлэх”, “Бие бүрэлдэхүүний алба хаах орчин нөхцөлийг сайжруулах” гэж тус тус заажээ. Тэгэхээр дээрх зорилтуудын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд биднээс үндэслэл, тооцоо бүхий нарийвчилсан судалгаанууд, лавлах өгөгдөхүүнүүд шаардагдсаар байгаа. Энэхүү Эрдэм шинжилгээний онол, практикийн хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүд нь “Цэргийн нэгтгэл, ангийн зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах”, “Цэргийн материал хэрэгслийн хангалтын тогтолцоог шинэчлэх”, “Бие бүрэлдэхүүний алба хаах орчин нөхцөлийг сайжруулах” зорилтуудыг шийдэхэд шаардлагатай, тулгамдсан асуудлуудыг хөндөж, төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг шийдэхэд өөр өөрсдийн хувь нэмрээ оруулахуйц сэдвүүдийн хүрээнд болж өнгөрлөө.

## НАМАР БОЛ УРЛАГ ЮМ

Зэвсэгт хүчний ар талын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд ЗХЖШ-ын жагсаалын талбайд “Алтан намар” үзэсгэлэн худалдаа дэлгэгдлээ. Тус үзэсгэлэн худалдаанд Зэвсэгт хүчний 310, 110, 186, 189, 234 зэрэг ангиуд өөрсдийн тарьж ургуулсан төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон туслах аж ахуйдаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ дээжээс авчирсан байв.

Тодруулбал, Зэвсэгт хүчний 310 дугаар анги өөрсдийн талхан цөхдээ бэлтгэсэн төрөл бүрийн талх, нарийн боов эгнүүлсэн бол Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийнхан утсан загас, шарсан тооройгоороо олны нүдийг хужирлаж байлаа. Түүнчлэн анги

бүр өөрсдийн аргаар бэлтгэсэн амтлаг ааруул цагаан идээ, төмс хүнсний ногоо болоод мах махан бүтээгдэхүүнийг өөр өөрсдийн асар майханд эгнүүлэн тавьсан байв.

/Үргэлжлэл нь арын нүүрт/



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 332.090 +1131	ЭДГЭРСЭН 439.616 +6146	НАС БАРСАН 1483 +14
-----------------------------------	---------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5693 +98	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 178	ЭДГЭРСЭН 5405
-----------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 241,878,076
Эдгэрсэн Нийт: 219,206,457
Нас барсан Нийт: 4,920,392

## Түүхэнд энэ өдөр

1996 он:

**Батлан хамгаалахын сайдын 601 тоот тушаалаар “Дуулга” телестуди байгуулагдав**

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-10

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	22

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,849.00	2,851.00
EUR	3,312,0	3,322,0
CNY	442,00	443,08
RUB	39,50	40,70
JPY	24,69	25,19
KRW	2,36	2,45

## ЗУРХАЙ

2021.10.19 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 14/

**НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал арвидна  
Наран ургах, шингэх:  
07.17-17.57  
Барилдлага:  
Үхэх  
Шүтэн барилдлага:  
Өтлөх үхэхүй  
Суудал:  
Үс

Тухайн өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адегуус муулах, лусыг тахих, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дархны үйлд сайн.

Улааны үйл, төлгө тавих, морь уралдах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар зүүн зүгт одогсоод мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

# НАМАР БОЛ УРЛАГ ЮМ

**Түрүүч нь эхний нүүрт/** Мөн хөхүүрийн шинэхэн айраг, халуун хайлмаг, халуун чацарганаар орсон гарсан зочдыг дайлж алтан намрын үр шимийг хүн бүрд мэдрүүлж байв.

Энэ үеэр ЗХЖШ-ын Материал, техникийн газраас энэ жилийн "Алтан намар" үзэсгэлэн худалдааны хүрээнд оролцож буй бүхий л офицер ахлагч, ажилтан алба хаагчдын дунд сугалаа явуулж ургац болон малын дээж болох хундан цагаан хонь, шуудай төмсийг нэг бус нэгжээд алба хаагчдад гардуулан өгсөн юм.

Энэ бүгд нь Зэвсэгт хүчний туслах аж ахуйн үр шим бөгөөд Зэвсэгт хүчний хэмжээнд туслах аж ахуйг үр ашигтай эрхлэн, цэргийн алба хаагчдын хүнсний хангалтыг тогтвортой, найдвартай эх үүсвэрээс хангах, туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж, бие бүрэлдэхүүний нийгмийн

хамгаалал, бэлэн байдал, бэлтгэлжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх өргөн боломжтой гэдгийг харуулж буй юм.

Түүнчлэн Монгол орон даяар өрнөсөн энэ жилийн намрын ургац хураалтын ажилд Зэвсэгт хүчний 24 нэгтгэл, ангийн 1800 гаруй цэргийн алба хаагч оролцож, ард иргэдийнхээ хүнсний аюулгүй, найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлсэн байна.



## ЦЭРЭГ ТАТЛАГА НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ЭНЭ САРЫН 21-НД ЭХЭЛНЭ



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НЗДТГ-ын Цэргийн штабаас өнөөдөр нийслэлийн цэрэг татлагын товчооны нэгдсэн хурлыг зохион байгууллаа. Тус хурлаар 2021-2022 оны хугацаат цэрэг татлагыг хэрхэн зохион байгуулах, цэргийн анги, цэрэг татлагын комиссууд хэрхэн ажиллах, юунд анхаарах талаар хэлэлцлээ.

Энэ үеэр мөн 2020-2021 оны цэрэг татлагаар халагдан ирсэн цэргүүдийг хэрхэн хүлээж авсан талаар мэдээлсэн юм. Тодруулбал, Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги, байгууллагаас халагдсан дайчдыг энэ сарын 15-16-ны өдрүүдэд хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн байна. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч байгууллагатай хамтран ажлын байранд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулжээ. Уг арга хэмжээнд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, Цагдаагийн газар, "Алтан боломж" сургалтын төв, "И-Март" худалдааны төв тэргүүтэй аж ахуй нэгж, байгууллагуудын хүний нөөцийн ажилтан, мэргэжилтэн нар оролцож, нийт 4500 гаруй ажлын байранд халагдсан цэргүүдийг зуучилжээ.

НЗДТГ-ын Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер, дэд хурандаа С.Баярмагнай "Нийслэлийн хэмжээнд хугацаат цэргийн албанд явсан цэргийн бүх алба

хаагчид албаа нэр төртэйгөөр хааж, 100 хувь халагдаж ирсэн. Бид өсөн дүүрэгт цэргүүдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, бүх төрлийн халамж үйлчилгээг үзүүлж, ажлын байранд зуучилсан" хэмээж байлаа.

Харин 2021-2022 оны хугацаат цэрэг татлагыг нийслэлийн хэмжээнд энэ сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар ажиллаж байна. Энэ талаар НЗДТГ-ын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер, хурандаа М.Мөнгөнтулга "Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын А/721 тоот захирамжийн дагуу нийслэлийн өсөн дүүрэгт 10 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг зохион

байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна. Цар тахалтай холбоотойгоор цэрэг татлагын байрыг тусгайлан бэлтгэсэн бөгөөд УОК-оос гаргасан халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахаар төлөвлөж байна" гэв.

Мөн энэ удаагийн цэрэг татлагаар Улаанбаатар цэргийн хүрээний ангиудад хуваарилагдсан залуусыг төв дамжинд цуглуулахгүй шууд ангид нь хүргэхээр зохицуулалт хийх аж.

Хугацаат цэргийн албанд татагдагчид нь иргэний үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, мэргэжил эзэмшсэн бол мэргэжлийн үнэмлэх, сургууль төгссөн бол диплом зэрэг баримт бичгээ биедээ авч, цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирэх үүрэгтэйг сануулж байлаа.



### Цахим шууданд

## ШИНЭ ДАЙЧДАА ХҮЛЭЭН АВЛАА



### Сонгино хайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

2021 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанаас Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргээс халагдаж ирсэн дайчдыг хүлээн авах арга хэмжээг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр "Чингис СОЭСЭ" сургуулийн спорт заланд зохион байгуулав.

Хугацаат цэргийн алба хааж халагдсан дайчдыг хүлээн авах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, холбогдох хэлтэс, төвүүд, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран бэлтгэл ажлыг хангасан юм. Халагдсан дайчдыг хүлээж авах ажиллагаанд СХД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Э.Мягмардаваа, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга С.Уугантуяа, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн, ажил олгогч байгууллагуудын төлөөлөл, байлдагчдын эцэг, эхчүүд оролцож, хуулийн дагуу хугацаат цэргийн алба нэр төртэй хаасан алба хаагчдад талархал дэвшүүлэн дурсамж гардуулан, холбогдох мэдээлэл, танилцуулгыг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд Хөдөлмөр, халамж

үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Зорчигч тээвэр-3 ОНӨТҮАН, Грийн групп, "Шилэн хийц" ХХК, "Эко Констракшн", "Алтан жолоо" импекс, "Гацуурт" ХХК, Номин холдинг, "Аравт" гэрээт харуул хамгаалалтын алба, "Хичээнгүй иргэдийн гэгээ" ТББ, "Эко констракшн ХХК, "Юнител" ХХК-ны төлөөлөгчид оролцож ажлын байрны зуучлал, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс болон аж ахуйн нэгж байгууллагын 70 гаруй төрлийн 2200 гаруй сул чөлөөтэй ажлын байрны захиалгатай оролцож, ажил мэргэжлийн чиг баримжаа

олгох, ажил хайх, ажлын байрны мэдээллийг хэрхэн олж авах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төсөл хөтөлбөр, залуучуудын гарааны бизнесийн хөтөлбөрийн талаар тус тус дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлсэн. Түүнчлэн хэлтсийн мэргэжилтнүүд хөдөлмөр зуучлалын үйлчилгээг 120 гаруй иргэн, Зорчигч тээвэр-3 ОНӨТҮ газар 11, Грийн групп 76, "Шилэн хийц" ХХК 89, "Эко Констракшн" 56, "Алтан жолоо импекс" 96, "Гацуурт" ХХК 60, "Номин холдинг" 120, "Аравт" гэрээт харуул хамгаалалтын алба 25 иргэнийг сул чөлөөтэй ажлын байрандаа бүртгэн ярилцлага хийж, ажлын байрандаа ирэхийг урьсан бол "Хичээнгүй иргэдийн гэгээ" ТББ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв мэдээлэл танилцуулга тараан "Юнител" ХХК-ны төлөөлөгчид "Ю" хөтөлбөрийн дугаарыг халагдсан дайчдад үнэ төлбөргүй олголоо.

Халагдсан цэрэг дайчдыг хүлээж авах ажлыг улсын Онцгой комиссын шийдвэр, дэглэмийг баримтлан ажиллалаа.

**Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ**

